



МОНГОЛ УЛСЫН
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 11 сарын 09 өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай

Шүүхийн захиргааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

1. Эрүүгийн эрх зүйн сургалтын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх нарийн бичгийн дарга /Т.Мэндсайхан/-д үүрэг болгосугай.


ДАРГА



Н.ЛҮНДЭНДОРЖ

000513

Шүүхийн ерөнхий зөвлөлийн
даргын 2015 оны 172 дугаар
тушаалын хавсралт



ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН
ХӨТӨЛБӨР

Нэг. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН
СУРГАЛТЫН ТОДОРХОЙЛОЛТ



СУРГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА:

Сургалтын нэр: Эрүүгийн эрх зүй
Сургалтын код: JU02
Нийт цаг: 24
Багц цаг: 3
Ангилал: Заавал судлах



Хөтөлбөрийн зорилго:

Албан тушаалын гэмт хэрэг, кибер гэмт хэрэг зэрэг зарим төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүн, зүйлчлэл тэдгээрийг шүүхэд хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал түүнчлэн шинжээчийн дүгнэлтийг үнэлэх арга зүй, шүүхээс хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах асуудлын талаар шүүгчдийн мэдлэгийг нэмэгдүүлнэ.



Агуулгын тодорхойлолт:

Нотлох баримтыг үнэлэх арга зүй болон шинжээчийн дүгнэлт: нотлох ажиллагаа түүний үе шат, шүүхийн шинжилгээний ойлголт, шинжээчийн дүгнэлтийг үнэлэх онцлог. Албан тушаалын гэмт хэрэг: гэмт хэргийн бүрэлдэхүүний онцлог, төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх, шүүхийн практик. Кибер гэмт хэрэг: Үндэсний

болон олон улсын эрх зүйн зохицуулалт, гэмт хэргийн бүрэлдэхүүний онцлог, төрөл болон зүйлчлэл, кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн нотлох баримтыг үнэлэх, шүүхийн шинжилгээний үйл ажиллагааг боловсронгуй болгох. Шүүхээс хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт. Эрүүгийн шүүх хуралдааныг удирдах мэтгэлцэх зарчмыг хангах асуудал: Мэтгэлцэх зарчмын агуулга, Мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх дараалал, Мэтгэлцээнд шүүгч хөндлөнгийн байх зарчим, түүнийг хэрэгжүүлэх арга зам.



Зорилт:

- Нотлох ажиллагаа түүний үе шат, шүүхийн шинжилгээ болон шинжээчийн дүгнэлтийг үнэлэх арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх;
- Албан тушаалын гэмт хэргийн бүрэлдэхүүний онцлог, төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх, шүүхэд хянан шийдвэрлэхэд тулгамдсан асуудлыг хамарсан мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх;
- Кибер гэмт хэргийн онцлог, бүрэлдэхүүн, кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэргийг нотлох зэргийн талаарх онол практикын шинэ мэдлэг эзэмшүүлэх;
- Шүүхээс хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах ЭБШХ-ийн 230 дугаар зүйлийн эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаарх мэдлэгийг гүнзгийрүүлэх;
- Эрүүгийн шүүх хуралдааныг удирдах, мэтгэлцэх зарчмыг хангах чадварыг дээшлүүлэх.



Оролцогчдын эзэмших мэдлэг, ур чадвар:

- Нотлох баримт, шүүхийн шинжилгээ, шинжээчийн дүгнэлтийн үнэлэх мэдлэг, чадвар дээшилнэ.
- Албан тушаалын болон кибер гэмт хэргийн талаар ойлголт, зүйлчлэл, иргэний маргаан, зөрчлөөс ялган шийдвэрлэх зэрэг хэрэг хянан шийдвэрлэхэд тулгарч буй асуудлын талаар ахисан түвшний мэдлэг эзэмшиж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадвар, арга барилд суралцана.
- Шүүхээс хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах талаар практикт тулгамдаж буй асуудлыг судалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах, эрүүгийн шүүх хуралдааныг удирдах, мэтгэлцэх зарчмыг хангах чадвар эзэмшүүлнэ.

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН СЭДЭВЧИЛСЭН
ТӨЛӨВЛӨГӨӨ, ЦАГ ХУВААРИЛАЛТ:

	Сургалтын сэдэв	Агуулга	Цаг
Сэдэв 1	Нотлох баримтыг үнэлэх арга зүй: шинжээчийн дүгнэлт	<ol style="list-style-type: none"> 1. Нотолгооны онол, арга зүй, орчин үеийн хандлага; 2. Нотлох баримтыг үнэлэх ерөнхий аргачлал; 3. Нотолгооны зүйлийн онцлог; 4. Шүүхийн шинжилгээ, түүнд тавигдах шаардлага; 5. Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх шүүгчийн эрх хэмжээ. 	6 цаг
Сэдэв 2	Албан тушаалын гэмт хэрэг	<ol style="list-style-type: none"> 1. Албан тушаалын гэмт хэрэг; 2. Төсөөтэй гэмт хэргээс ялгах нь; 3. Албан тушаалын гэмт хэргийг шүүхэд; хянан шийдвэрлэж буй практик. 	6 цаг
Сэдэв 3	Кибер гэмт хэрэг	<ol style="list-style-type: none"> 1. Кибер гэмт хэрэг, түүний бүрэлдэхүүний онцлог, төрөл; 2. Монгол улс дахь гэмт хэргийн төлөв байдал; 3. Олон улсын ба үндэсний эрх зүйн эх сурвалж; 4. Шүүхэд цахим нотлох баримтыг үнэлэх, шүүхийн шинжилгээг боловсронгуй болгох. 	4 цаг
Сэдэв 4	Шүүхээс хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах	<ol style="list-style-type: none"> 1. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн зарчим; 2. Шүүхээс хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах ажиллагааны үндэсний эрх зүйн зохицуулалт; (ЭБШХ-ийн 80, 208 дугаар зүйлүүд) 3. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт, зарчим ба ЭБШХ-ийн 230 дугаар зүйл хоорондын уялдаа холбоо; 4. Гадаад улсын ЭБШХ-ийн зохицуулалт, хэргийг буцаадаггүй туршлагаас. 	6 цаг
Сэдэв 5	Эрүүгийн шүүх хуралдааныг удирдах, мэтгэлцэх	<ol style="list-style-type: none"> 1. Эрүүгийн шүүх хуралдааныг удирдах буюу шүүх хуралдааны дэг, дараалал, менежмент; 	2 цаг

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

зарчмыг асуудал	хангах	2. Эрүүгийн шүүх хуралдааныг удирдах онцлог; 3. Эрүүгийн шүүх хуралдаанд мэтгэлцэх зарчмыг хангах, мэтгэлцэх зарчмын олон улсын болон үндэсний эрх зүйн эх сурвалж.	
Нийт			24 цаг



Сургагч багшид тавих шаардлага

Мэргэжил:

Эрүүгийн эрх зүйн сургалтыг удирдан явуулах сургагч багш нь эрүүгийн эрх зүй болон шүүн таслах ажлын чиглэлээр онол, арга зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, гадаад хэлнээс орчуулга хийх чадвартай, судалгааны ажлын зохих туршлагатай байна.

Заах арга зүй:

- Лекц унших болон дадлагажуулах сургалтыг удирдах арга зүйг эзэмшсэн байх;
- Сургалтад оролцогчидтой хамтран ажиллах, бүлгийн хэлэлцүүлэг болон мэдлэг бүтээх үйл явцыг удирдаж чаддаг байх;
- Оролцооны идэвхтэй аргуудыг ашиглан сургалт явуулах талаар зохих мэдлэг, туршлагатай байх.

Бусад шаардлага:

- Сургалтын материал, хэрэглэгдэхүүн бэлтгэх, ашиглах талаар санаачлагатай байх;
- Оролцогчдод зориулсан гарын авлага, тараах материалыг товч, тодорхой, ойлгоход хялбар аргаар бэлтгэх;
- Харилцааны болон багшийн ёс зүйн өндөр мэдрэмжтэй байх;
- Сургалтын үнэлгээ хийх арга зүйг эзэмшсэн, сургалтад оролцогчдын мэдлэг, ур чадварын өөрчлөлтийг бодитой үнэлдэг байх.

Сургалтын үнэлгээ:

Сургалтын үр дүн, ач холбогдол, сургагч багшийн ур чадварыг тусгайлан боловсруулсан “Үнэлгээний асуулга”-ын тусламжтайгаар үнэлнэ. Үнэлгээний тайланг шүүгчийн хуулийн хэрэглээг дээшлүүлэх буюу эрүүгийн эрх зүйн чиглэлээр зохион байгуулах дараагийн сургалтын сэдэв, чиглэлийг тодорхойлох, сургагч багшийг сонгоход ашиглана.

Хоёр. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН ТОВЧ АГУУЛГА

СЭДЭВ 1. НОТЛОХ БАРИМТЫГ ҮНЭЛЭХ АРГА ЗҮЙ: ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

Сэдвийн зорилго: Нотолгооны онол, арга зүйн орчин үеийн чиг хандлага, шүүхийн шинжилгээ, шинжээчийн дүгнэлт, түүнийг үнэлэх шүүгчийн эрх хэмжээний талаар мэдлэгийг дээшлүүлнэ.



Нэр томьёо

- Нотлох баримт
- Шинжээч
- Шүүхийн шинжилгээ
- Шинжээчийн дүгнэлт
- Шинжээчийн мэдүүлэг
- Гэрчийн мэдүүлэг
- Хохирогчийн мэдүүлэг
- Сэжигтэний мэдүүлэг
- Эд мөрийн баримт
- Гэрэл зураг
- Соронзон бичлэг
- Дүрс бичлэг
- Хэрэг бүртгэлтийн тэмдэглэл
- Мөрдөн байцаалтын тэмдэглэл
- Шүүх хуралдааны тэмдэглэл
- Дотоод итгэл



Сэдвийн агуулга

Нотолгооны онол, арга зүй, орчин үеийн хандлага. Нотлох баримтыг үнэлэх ерөнхий аргачлал. Нотолгооны зүйлийн онцлог. Шүүхийн шинжилгээ, түүнд тавигдах шаардлага. Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх шүүгчийн эрх хэмжээ.



Хяналтын асуулт

- Эд мөрийн баримтыг хураан авахдаа уг ажиллагаанд заавал байлцуулах хүмүүсийг оролцуулаагүй нь тогтоогдвол шүүгч тухайн болон бусад нотлох баримтуудыг хүчингүйд тооцож ажиллагааг дахин явуулахыг шаардах нь зүйтэй юу? Үндэслэлээ тайлбарлана уу.
- Нотлох ажиллагааны үе шатуудыг хэлэлцэж, шалгах ба үнэлэх ажиллагааны ялгаа, онцлогийг тодорхойлно уу.
- Шинжээчийн дүгнэлт тодорхойгүй гэдэгт хамаарах асуудлыг хэлэлцэнэ үү. Тэрхүү дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэх вэ?
- Нэмэлт болон дахин шинжилгээний ялгагдах гол онцлогийг тодорхойлж, тэдгээрийг ижил мэргэжлийн шинжээчдийн бүрэлдэхүүнээр хийлгэж болох эсэхийг ярилцаарай.



Эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002 он
3. Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002 он
4. Монгол Улсын Дээд Шүүхийн тойм. 2014 оны 12 дугаар сарын 23
5. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль: Шинжлэх ухааны тайлбар, (Ханнс зайдлийн сан) УБ, 2003 он
6. Амарбаясгалан Б, Эрхэсхулан Ж. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, УБ.,2007
7. Батзориг Б. Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол, УБ, 2002 он
8. Батзориг Б. Докторын ажил “Эрүүгийн хэргийн нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны онол, практикийн асуудал”
9. Бат-Эрдэнэ Б нар. Шүүгчийн гарын авлага, УБ, 2004 он
10. Баярсайхан Д. Эрх зүйн онол, УБ хот, 2000 он
11. Галдаа Б. Нотолгооны эрх зүйн үндсэн асуудал, УБ, 2008 он
12. Лхагвасүрэн А, Баясгаланбат Н. Криминалистик, УБ, 2013 он
13. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь, УБ, 1966 он
14. Шүүхийн шинжилгээний байгууллагын 2013 оны ажлын мэдээ
15. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь шинжилгээ, 2006 он
16. Винберг А.И, Малаховская Н.Т. Судебная экспертиология, Волгоград.г., 1979 г.
17. Лекции по дисциплине ”Проблемы судебной экспертизы”// fgiseo.npi-tu.ru/admin/spaw2/.../Lekcii.doc//
18. Комментарий к Уголовному кодексу Россииской Федераций 7-е издание.2010г

19. Гуценко К.Ф, Головки Л.В. Уголовный процесс западных государств, М.,2001 г
21. Кают Ё. Шүүхийн шийдвэр,тогтоол бичих аргачлал, УБ, 2005 он
22. Юридический энциклопедический словарь., Москва., 1984.,
23. www.legalinfo.mn

СЭДЭВ 2. АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ

Сэдвийн зорилго: Албан тушаалын гэмт хэргийн бүрэлдэхүүний онцлог, төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх, шүүхэд хянан шийдвэрлэхэд тулгамдсан асуудлын талаарх мэдлэг, чадварыг нэмэгдүүлнэ.



Нэр томьёо

- Албан тушаал
- Авлига
- Ашиг сонирхлын зөрчил
- Төрийн албан тушаалтан
- Хээл хахууль
- Бэлэг
- Шан харамж
- Эрх мэдлээ хэтрүүлэх
- Үндэслэлгүйгээр хөрөнгөжих



Сэдвийн агуулга

Албан тушаалын гэмт хэрэг, бүрэлдэхүүний онцлог, төсөөтэй гэмт хэргээс ялгах нь. Албан тушаалын гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийн практик, тулгамдаж буй асуудал. Албан тушаалын гэмт хэргийн статистикт дүн шинжилгээ хийх.



Хяналтын асуулт

- Эмнэлгийн байгууллагын тасгийн эрхлэгч өвчтэй хүнд тусламж үзүүлэх үүрэгт ажилдаа хайнга хандсан бол ЭХ-ийн 106 дугаар зүйл, барилгын чанарт хяналт тавих үүрэгтэй албан тушаалтан үүрэгт ажилдаа хайнга хандсан бол ЭХ-ийн 174 дүгээр зүйл, аюулгүйн ажиллагааны дүрэмд

хяналт тавих үүрэгтээ хайнга хандсан албан тушаалтанд ЭХ-ийн 183 дугаар зүйлээр хариуцлага хүлээлгэсэн нь албан тушаалын гэмт хэргээс юугаараа ялгагдаж байна вэ?

- Авлига (corruption) болон хээл хахууль (Bribe) гэсэн 2 ойлголтын ялгааг тодруулна уу. Авлигын субъект бол зөвхөн албан тушаалтнууд, харин хээл хахуулийн субъект хэн байж болох вэ?
- “Баян болдог” ХХКомпаний захирал О нь дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн улсын байцаагч Д-ээр өөрийн компанийн дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг хугацаанаас нь өмнө буюу хууль бус аргаар сэргээлгэж авах зорилгоор түүнд 500.000 төгрөгийн хээл хахууль өгсөн. Гэтэл улсын байцаагч Д нь Мэргэжлийн хяналтын хэлтсийн улсын байцаагч мөн боловч архи, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий ажилтан биш байжээ. Зүйлчлэлийг тодорхойлж бусад гэмт хэрэг, зөрчлөөс ялгагдах онцлогийг тайлбарлана уу.



Эх сурвалж

1. Авлигын эсрэг хууль, 2006 он
2. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
3. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002 он
4. НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, 2003 он
5. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенц, 2000 он
6. Азийн сан, Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүүгийн хууль тогтоомжийг хэрэглэж байгаа байдлыг судалсан судалгааны ажил, 2013 он
7. Батзориг Б, Цэлмэг Ц, Одонгэрэл Б, Оюунболд Г нар, Авлига, албан тушаалын гэмт хэрэг, УБ, 2014 он
8. Бямбаа Ж, Баясгалан Б, “Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд”, УБ, 1998 он
9. Дэлхий нийтийн авлигын тайлан, Шүүхийн тогтолцоон дахь авлига, 2007 он.
10. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм, 1998 он
11. Жереми Поуп, Авлигын эсрэг сурвалж бичиг, УБ, 2003 он
12. www.criminal-procedure.da.ru

СЭДЭВ 3. КИБЕР ГЭМТ ХЭРЭГ

Сэдвийн зорилго: Кибер гэмт хэргийн үндэсний болон олон улсын эрх зүйн зохицуулалт, кибер гэмт хэргийн төрөл, бүрэлдэхүүн түүний зүйлчлэл, цахим нотлох баримт түүнийг шүүхэд үнэлэх, шүүхийн шинжилгээг боловсронгуй болгох талаар онол, практикийн мэдлэгийг гүнзгийрүүлнэ.



Нэр томьёо

- Шинэ төрлийн гэмт хэрэг
- Кибер гэмт хэрэг
- Компьютерийн гэмт хэрэг
- Кибер халдлага
- Интернет эдийн засаг
- Даяарчлал
- Криптограф
- мэдээллийн ажиллагаа
- террорист ажиллагаа
- цахим баримт бичиг
- цахим засаг (electronic government, e-gov)
- үүлэн тооцоолол
- зөвшөөрөгдөөгүй хандалт (unauthorized access)
- компьютерийн сүлжээ
- мэдээллийн нууцлал



Сэдвийн агуулга

Кибер гэмт хэрэг, төрөл, түүний бүрэлдэхүүний онцлог. Монгол Улс дахь кибер гэмт хэргийн төлөв байдал. Олон улсын болон үндэсний эрх зүйн эх сурвалж. Цахим нотлох баримт, тоон шинжилгээ, шүүхэд цахим нотлох баримтыг үнэлэх, шүүхийн шинжилгээг боловсронгуй болгох.



Хяналтын асуулт

- Кибер гэмт хэрэг, компьютерийн гэмт хэрэг гэсэн ойлголт ялгаатай юу? Аль нь өргөн хүрээний гэмт хэргийг хамрах вэ?
- Компьютерийн мэдээлэл, сүлжээний эсрэг гэмт хэрэгт ямар хууль бус үйлдлийг ойлгох вэ?

- Интернетийн сүлжээгээр дамжуулан мөнгө угаах асуудлыг ЭХ-ийн 166¹ дүгээр зүйлд зохицуулсан эсэхийг тайлбарлана уу?
- Интернэт дэх зохистой агуулгын эсрэг гэмт хэрэгт садар самуун, хүүхдийн порнограф орох уу?



Эх сурвалж

1. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002 он
2. Эрүүгийн хуулийн төсөл, 2015 он
3. Баярсайхан Д. Харьцуулсан Эрүүгийн эрх зүй.УБ., 2011 он, 95 дахь тал
4. Д. Золжаргал, Г. Оюунболд. Компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн криминологийн зарим асуудал. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2008 он №2/21/
5. Ж.Амарсанаа , Д.Баянбилэг “Эрүүгийн хэрэг , эрх зүйн баримт бичгийн эмхтгэл”, УБ, 2012 он
6. Жанцан С. “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй Ерөнхий ба Тусгай анги” УБ хот 2012 он
7. Жанцан С. “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн практикум Ерөнхий ба Тусгай анги”, УБ, 2012 он
8. Л.Галбаатар. “Цахим эрх зүй” блог (www.galbaatar.blogspot.com)
9. Л.Галбаатар. Цахим эрх зүй (нэг сэдэвт бүтээл). Улаанбаатар. 2010
10. Монгол Улсын Дээд шүүх, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Улаанбаатар. 2013. 558-565 дахь тал
11. Ө.Эсболд. Тоон шинжилгээ (илтгэл). Улаанбаатар. 2013
12. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ, 2012
13. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Цахим орчин дахь хүүхдийн эрхийн хамгаалалт (бодлогын судалгаа). Хууль зүйн үндэсний хүрээлэн. "Хууль дээдлэх ёс" сэтгүүл. Тусгай дугаар. Цуврал 46. Улаанбаатар. 2013
14. Ц.Хүрэл-Очир. Виртуал гэмт хэрэг-Susan W.Brenner “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2008 он №2/21/
15. Ц.Хүрэл-Очир.Компьютерийн гэмт хэрэг. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2006 он №2
16. Marco Gercke, Project on Cybercrime, Council of Europe. Cybercrime training for judges: Training manual (draft). 2010
17. Model Criminal Code. O.Conner.C.Raush edi.W.v2007

18. Project on Cybercrime; Lisbon Network of Judicial Training Institutions of the Council of Europe. Cybercrime training for judges and prosecutors: a concept. 2009
19. Zahid Jamil. Cybercrime Model Laws. Discussion paper prepared for the Cybercrime Convention Committee (T-CY). 2014

СЭДЭВ 4. ШҮҮХЭЭС ХЭРГИЙГ ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТАД БУЦААХ

Сэдвийн зорилго: ЭБШХ-ийн 230 дугаар зүйлд заасан хэргийг шүүхээс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах асуудлаар орчин үеийн чиг хандлагаар хандах мэдлэг чадварыг эзэмшүүлнэ.



Нэр томьёо

- Хэрэг буцаах
- Хэргийг нэгтгэх
- Хэргийг тусгаарлах
- Урьдчилсан хэлэлцүүлэг
- Прокурорын эсэргүүцэл
- Нэмэлт ажиллагаа хийх
- Бүрэн биш
- Хуулийг ноцтой зөрчсөн
- ЭБШХ-ийн зарчим



Сэдвийн агуулга

Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн зарчим. Шүүхээс хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах үндэслэл, журам түүний хэрэгжилт. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт ба ЭБШХ-ийн 230 дугаар зүйл хоорондын уялдаа холбоо. Гадаадын зарим улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохицуулалтыг харьцуулан судлах.



Хяналтын асуулт

- Дээд шатны шүүх ямар үндэслэлээр хэргийг прокурорт буцаахыг ЭБШХ-ийн 315, 350 дугаар зүйлд заагаагүй нь эдгээр шүүх нь мөн хуулийн 230

дугаар зүйлийг баримтална гэж үзэж болох уу? Үндэслэлийг тайлбарлана уу.

- 2015 оны Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах асуудлыг зөвхөн прокурорын саналыг шүүх хангаж шийдвэрлэнэ гэсэн нь одоогийн хуулийн заалттай харьцуулбал ямар өөрчлөлтийг авчрах вэ?
- Шүүгдэгч Бат ажил хайгаад олдохгүй байсан, гэр бүлийн байдал ядуу учраас хулгайн гэмт хэрэг үйлдсэн гэжээ. Мөрдөн байцаагч зөвхөн хулгайлсан үйлдийг нотолсон тул Батыг үнэхээр ажил хайсан эсэх, гэр бүл нь ядуу эсэхийг нотлох нь хэрэгтэй гэж хэргийг нэмэлт ажиллагаанд буцаажээ. Энэхүү шийдвэр зөв үү?



Эх сурвалж

1. Казахстан улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль,
2. Латви улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2005
3. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002 он
4. ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль,
5. Франц улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 1985
6. ХБНГУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 1877
7. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002 он
8. Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл, 2015 он
9. Амарсайхан Ц, Амарсанаа Ж. “Процессийн эрх зүй онол, туршлага”, УБ, 2014 он
10. Ганболд, “Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй”, УБ, 2010 он.
11. ХЗҮХ, “Эрүүгийн байцаан шийтгэх хууль дахь шүүхээс хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах талаарх зохицуулалт” судалгааны тайлан, 2012 он.

СЭДЭВ 5. ЭРҮҮГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫГ УДИРДАХ, МЭТГЭЛЦЭХ ЗАРЧМЫГ ХАНГАХ

Сэдвийн зорилго: Эрүүгийн шүүх хуралдааныг удирдах, мэтгэлцэх зарчмыг хангах чадварыг эзэмшүүлнэ.



Нэр томьёо

- Оролцогчдын эрх үүрэг
- Шударгаар шүүгдэх эрх
- Эрх тэгш байх

- Нээлттэй шүүх хурал явуулах журам
- Мэтгэлцэх журам
- Тэгш боломж
- Эсрэг талуудын үйл ажиллагааг хүндэтгэн мэтгэлцэх зарчим
- Байцаан шийтгэх ажиллагааг шуурхай явуулах зарчим
- Шүүх хуралд оролцох эрх
- Урьдчилсан хэлэлцүүлэг (Pre trial)
- Шүүх хуралдааны дэг, дараалал, менежмент
- Нээлтийн ажиллагаа
- Хэргийн онол
- Шүүхийн хэлэлцүүлэг
- Шууд байцаалт
- Зөрүүлсэн байцаалт
- Шүүмжлэлийн үе шат
- Өмгөөллийн үе шат
- Шүүгдэгчийн эцсийн үг



Сэдвийн агуулга

Эрүүгийн шүүх хуралдааныг удирдах буюу шүүх хуралдааны дэг, дараалал, менежмент. Мэтгэлцэх зарчмын агуулга. Мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх дараалал буюу эрүүгийн шүүх хуралдаанд мэтгэлцэх зарчмыг хангах. Мэтгэлцэх тогтолцооны онцлог: шүүхийн өмнөх шат, шүүхийн шат, шүүх хуралдааны дараах шатан дахь үйл ажиллагаа. Мэтгэлцээнд шүүгч хөндлөнгийн байх зарчим, түүнийг хэрэгжүүлэх арга зам. Мэтгэлцэх зарчим, шударгаар шүүгдэх эрхийн харилцан хамаарал. Мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх үндэслэл, журам. Мэтгэлцэх зарчмын олон улсын болон үндэсний эрх зүйн эх сурвалж.



Хяналтын асуулт

- Шүүн таслах ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх онолын болон практик үндэслэл юу вэ?
- Мэтгэлцэх зарчмыг бодитой хэрэгжүүлэх нь шүүгчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх гол арга байж болох уу?
- Шүүх хуралдаанд мэтгэлцэх зарчмыг хангаж, шүүх хуралдааныг удирдах менежментийг сайжруулах талаар ямар санал хэлэх вэ?
- Мэтгэлцэх зарчмыг хангаж, талуудыг эрх тэгш шүүх хуралдаанд оролцуулахад анхаарах зүйлс?



Эх сурвалж

1. Б.Бат-Эрдэнэ, “Манай хуульд мэтгэлцэх зарчмын агуулга бүрэн тусгагдаагүй”, Монголын төр эрх зүй, №1/57/, 2009.
2. Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хуульд мэтгэлцэх зарчмыг хуульчлан тусгасан нь, өгүүлэл. Шударга ёс сэтгүүл, УБ., 2011.
3. Д.Баярсайхан. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. УБ., 2014.
4. Д.Зүмбэрэлхам. “Шүүхийн мэтгэлцээн” гарын авлага, УБ., 2002.
5. Л.Мөнхсайхан. “Мэтгэлцэж сурахуй” Монголын төр эрх зүй сэтгүүл, №4/58/, 2009.
6. Л.Мөнхсайхан. “Шүүн таслах ажиллагаан дахь мэтгэлцээний зарчмуудын агуулга ач холбогдол” Монголын төр эрх зүй сэтгүүл, №2/60/, 2010.
7. Мэтгэлцэх ур чадвар: гарын авлага. УБ., 2009.
8. Мэтгэлцээний тухай http://clubuud.blogspot.com/2010/04/blog-post_26.html
9. Х.Батчимэг, “Шүүх хуралдаанд прокурорын гүйцэтгэх чиг үүрэг, улсын яллагчаар оролцож, мэтгэлцэх нь”, 2013. <http://lawstudent.blog.gogo.mn/read/entry394600>
10. Хууль зүйн клиник: гарын авлага. “Хууль зүйн клиник, хууль зүйн зөвлөгөө, шүүхийн мэтгэлцээн” Дэлхийн банкны Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл, 2013 он
11. Ц.Бүжинлхам. Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй /тусгай анги/ Шүүхийн ажиллагаа, УБ., 2007.
12. Ц.Оч, “Анхан шатны эрүүгийн шүүх хуралдааныг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулахад анхаарах зарим асуудлын талаар”, Монголын төр эрх зүй, №1/57/, 2009
13. Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр “Шүүх хуралдааны мэтгэлцэх ур чадвар: видео хичээл”. УБ., 2009.
14. Эмнести Интернэшнл. “Шударгаар шүүгдэх эрх” гарын авлага, УБ., 2011.
15. Advocacy for Victims of Crime <http://crcvc.ca/docs/advocacy.pdf>
16. Basic Principles on the Role of Lawyers <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/RoleOfLawyers.aspx>
17. Criminal Trial Advocacy <http://trial-advocacy.homestead.com/>
18. Richard Klein “The Role of Defense Counsel in Ensuring a Fair Justice System” <https://www.nacdl.org/champion.aspx?id=24996>
19. Steven Lubet “Modern Trial Advocacy: Analysis and Practice” National Institute for Trial Advocacy, 2004.
20. THE ROLE OF JUDGES AND ADVOCATES <http://www.nadr.co.uk/articles/published/LegalSkillsAndPractice/JudgesandLawyers.pdf>

